

Монголын эмэгтэйчүүдийн хэвлэл:

“Бүсгүйчүүдийн тасгаас явуулсан бүхий л хэргүүдийн тухай бичиж, мөн бүсгүйчүүдийг боловсрох сурахад дөхөм тустай зураг, дэвтэр сэтгүүлийг хэвлэж тарааваас зохино” гэсэн МАХН-ын Төв Хорооны 1925 оны 3-р бүгд хурлын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор МАХН-ын Төв хорооны дэргэдэх бүсгүйчүүдийн тасгаас эрхлэн “Бүсгүйчүүдийн санал” нэртэй сэтгүүлийг бий болгож, анхны дугаарыг “Бүсгүйчүүдийн тасаг байгуулагдсаны нэг жилийн ой”-гоор буюу 1925 оны 3-р сарын 19-ны өдөр гаргажээ. Сэтгүүлийн анхны дугаар 33,7см X 24,5см-ийн хэмжээтэй, хавтсан дээрээ “Бүсгүйчүүдийн эрх чөлөө мандтугай” гэсэн лоозон барьсан эмэгтэйчүүдийн жагсаалын зурагтай хэвлэгдэн гарчээ.

МАХН-ын Төв хорооны шийдвэрээр бүсгүйчүүдийн тасгийн эмэгтэйчүүдийн хэлтэс болсны дараа 1926 оны 3-р сараас 1928 оны 6-р сар хүртэл хугацаанд “Эмэгтэйчүүдийн санал” нэртэй сэтгүүл гарах болжээ. “Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүлийн тав дахь дугаараас эхлэн НТХ-ны эмэгтэйчүүдийн хэлтэс Улаанбаатар хотын намын хорооны эмэгтэйчүүдийн тасагтай хамтран гаргадаг болжээ. Энэ үеэс сэтгүүлийн хэмжээ анхныхаас бага зэрэг багасч 17x13 см-ийн хэмжээтэй хавтсан дээрээ “Эмэгтэйчүүдийн эрх чөлөө бадартугай”, “Ардын зориг нь гайхамшиг” гэсэн үгтэй туг барьсан эмэгтэй нарны зүг зааж байгаа зурагтай хэвлэгдэн гарч байжээ. Энэ сэтгүүл нийт 8 дугаар гаргасан байна. 1929 оны 4-р сараас 12-р сар хүртэл хугацаанд уг сэтгүүлийн 9, 10-р дугаарууд “Эмэгтэйчүүдийн эрх” нэртэй хэвлэн гарчээ. Эмэгтэйчүүдийн хэлтсээс эмэгтэйчүүдэд зориулан сар дутам гаргадаг сэтгүүлийн 11 дэх дугаарыг “Ажилч эмэгтэй” гэсэн нэртэйгээр улмаар “Ажилчин эмэгтэй” хэмээн нэрлэж 1932 он хүртэлх хугацаанд бүгд 11 удаа хэвлэн гаргажээ. Сэтгүүлийн хавтсан дээр “Газар бүрийн эмэгтэй нар нэгдэгтүн” гэсэн уриаг тодоор бичсэн байв. Харин 1936 оноос 1960 он хүртэлх 24 жилийн хугацаанд эмэгтэйчүүдийн ямар нэгэн сонин сэтгүүл хэвлэгдэн гараагүй байна.

Олон Улсын эмэгтэйчүүдийн эв санааны нэгдлийн өдөр Мартын 8-ны 50 жилийн ойг тохиолдуулан 1960 онд “Монголын эмэгтэйчүүд” нэртэй сэтгүүлийг монгол, орос, англи хэл дээр хэвлэн гаргажээ. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1961 оны 159 дүгээр тогтоолын 5 дахь зүйлд “Монголын эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр, аж байдлыг гадаад, дотоодод сурталчлах зорилгоор “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийг жилд 2 удаа гаргаж байхыг эмэгтэйчүүдийн тасагт даалгасугай” гэж заажээ. Ийнхүү монголын эмэгтэйчүүдийн хэвлэл дахин сэргэсэн юм. Энэ явдалд Монголын эмэгтэйчүүдийн хорооны орлогч дарга бөгөөд сэтгүүлийн эрхлэгч Түмэнжаргалын Должин чухал үүрэг гүйцэтгэжээ. “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүл олон арван эмэгтэйчүүдийн ажил үйлсийг олон нийтэд хүргэж нэр нь тодроогүй баатруудыг тодруулж байсан ба эмэгтэйчүүдэд хэрэгтэй зөвлөлгөө, төрөл бүрийн сургалтын материал нийтлэгддэг учир манай эмэгтэйчүүдийн унших дуртай сэтгүүлийн нэг болж уншигчдынхаа тоогоор дээргүүрт ордог байв. “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийн 50 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 1974 оны 4-р сарын 24-ны өдрийн 114-р тогтоол гарч, ойг угтаж сэтгүүлийн агуулга, үзэмжийг сайжруулахыг Монголын эмэгтэйчүүдийн хороонд даалгажээ. “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийн 50 жилийн ойг тохиолдуулан 1975 оны 3-р сарын 19-ны өдөр баярын хурал зохион байгуулж, хуралд МАХН-ын Төв Хорооноос баярын бичиг ирүүлсэн байна. Үүнийг бүрэн эхээр толилуулья.

“Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийн газарт

“Монголын эмэгтэйчүүд” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарсны 50 жилийн ойг тохиолдуулан тус сэтгүүлийн газрын хамт олон, идэвхтэн бичигчид, нийт уншигчидад МАХН-ын Төв Хороо халуун баяр хүргэж байна.

“Бүсгүйчүүдийн санал” нэртэйгээр 1925 оны 3-р сард анхны дугаар нь хэвлэгдэн гарсан “Монголын эмэгтэйчүүд” сэтгүүл бол Ардын хувьсгалын ололтыг хамгаалан бэхжүүлэх, эх орондоо социалист нийгэм бүтээн байгуулахын төлөө манай яруу алдарт эмэгтэйчүүдийн шаргуу тэмцлийн түүхтэй салшгүй холбоотой юм. Хувьсгалын анхны жилүүдээс эхлэн монголын хөдөлмөрчин эмэгтэйчүүдийг соён гэгээрүүлж, хувьсгалт үзэл санаагаар хүмүүжүүлэн феодализмын олон үеийн бурангуй хоцрогдлоос ангижруулж, шинэ нийгэм цогцлон байгуулагч

болгон хүмүүжүүлэх талаар МАХН-ын удаа дараагийн программд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үйлсд "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүл хамтын суртал нэвтрүүлэгч, ухуулагч, хамтын зохион байгуулагчийн үүргээ нэр төртэй биелүүлж ирсэн байна.

Хөдөлмөрчин эмэгтэйчүүдийг марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчимд чин үнэнч үзэл санаагаар хүмүүжүүлж, БНМАУ-д социализмын ялалтыг бүрэн хангах, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг өндөржүүлэх, улс ардын аж ахуй соёлын төлөвлөгөөг ханган биелүүлэх хэрэгт тэдний улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэхэд ажлаа чиглүүлэх явдал "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлийн гол зорилт болж байна. Орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололт амжилтаас суралцаж, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ахуйн соёлыг өндөржүүлэх, үр хүүхдээ зөв боловсон хүмүүжүүлэхэд нь эмэгтэйчүүдэд бүхий л талаар нөлөөлж, ЗХУ болон ах дүү социалист орны эмэгтэйчүүдийн байгууллагын ажлын баялаг туршлагыг дэлгэрүүлэх, зөвлөлтийн эмэгтэйчүүдийн коммунист байгууллагын баатарлаг үйлсийг сурталчлахад эмэгтэйчүүдийн хэвлэл чухал үүрэг гүйцэтгэх ёстой. "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүл өргөн олон уншигчтай холбоогоо улам бэхжүүлж, сэтгүүлийн агуулга, үзэл суртлын түвшин, үр нөлөөг цуцалтгүй дээшлүүлэн намын үзэл суртлын дайчин хурц зэвсэг байх үүргээ цаашид ч нэр төртэй биелүүлнэ гэдэгт МАХН-ын Төв Хороо итгэж байна

МАХН-ын Төв Хороо.

Монголын эмэгтэйчүүдийн хэвлэл үүсч хөгжсөний 50 жилийн ойд зориулсан баярын хурал дээр Монголын эмэгтэйчүүдийн хорооны орлогч дарга бөгөөд "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлийн эрхлэгч Т.Должин илтгэл тавьжээ. Энэхүү илтгэлийг дор сийрүүлэв.

Нөхөд өө,

Өнөөдөр Монголын эмэгтэйчүүдийн хорооны хэвлэл "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарсны хагас зуун жилийн ойг манай хөдөлмөрчин эмэгтэйчүүд нийт ард түмнийхээ хамт баяр баясгалантай ёслол тэмдэглэж байна.

Монголын эмэгтэйчүүдийн сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарсны хагас зуун жилийн түүхт ойг тохиолдуулан Монгол Ардын Хувьсгалт Намын Төв хороо баярын бичиг ирүүлсэн болон тус сэтгүүлийн БНМАУ-ын төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон"-гоор шагнасан нь манай нам хувьсгалт хэвлэлийг бэхжүүлэхийн төлөө асар их халамж анхаарал тавьж түүний гүйцэтгэж байгаа үүргийг өндөр үнэлдгийн нэг тод илрэл бөгөөд энэ нь сэтгүүлийн хамт олон, түүний олон мянган идэвхтэн бичигч, уншигч хөдөлмөрчин эмэгтэйчүүд, залуучуудын урам зоригийг бадрааж, нам засгийнхаа хайр халамжийн хариуд улам ихийг бүтээх хүсэл эрмэлзлэлийг оргилуулж байна.

Монголын эмэгтэйчүүдийн хэвлэлийн туулж өнгөрүүлсэн түүхэн замналыг дүгнэж цаашдын зорилтыг яруу тодорхой заасан баярын бичиг ирүүлсэн болон төрийн эрхэм дээд шагнал хүртээсэн явдалд хайрт нам засагтаа манай орны нийт эмэгтэйчүүдийн халуун баяр талархалыг дэвшүүлье.

... МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр 1925 оны 3 дугаар сарын 19-нд Намын Төв Хорооны бүсгүйчүүдийн тасгийн дэргэд "Бүсгүйчүүдийн санал" сэтгүүлийг үүсгэн бий болгосон тэр тэр үеэс эхлэн тус сэтгүүл манай орны хөдөлмөрчин эмэгтэйчүүд, түүний байгууллагын түүхийг бичилцэж эхэлсэн билээ. Ингэж монголын эмэгтэйчүүд түүхэндээ анх удаа биеэ даасан хэвлэлтэй болж шинэ нийгмийн эрх чөлөөт тэгш эрхт гишүүн гэдгээ бас дахин баталлаа.

Монголын эмэгтэйчүүдийн хэвлэл монгол ардын хувьсгалын ардчилсан шатны эхэн үед төрж, манай намаас эх орныхоо түүхэн хөгжлийн үе шат бүхэнд эмэгтэйчүүд, эхчүүд, үр хүүхдийн талаар дэвшүүлэн тавьсан зорилтыг хэрэгжүүлэх тухайлбал, дундад зууны феодализмын бурангуй байдлаас тэднийг ангижруулан эрэгтэйчүүдтэй адил тэгш эрх эдлүүлж, улмаар улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд идэвхтэй оролцуулах, эмэгтэйчүүдийг марксизм-ленинизм, пролетарийн интернационализмын зарчим, социализмын үйл хэрэг, монгол-зөвлөлтийн ард түмний найрамдалд чин үнэнч, эх оронч үзэлтэй, өв тэгш соёл боловсролтой иргэн болгон хүмүүжүүлэхэд хамтын ухуулагч, хамтын суртал нэвтрүүлэгч, хамтын зохион байгуулагчийн үүргээ нэр төртэй биелүүлсээр ирсэн билээ.

“Бүсгүйчүүдийн санал” сэтгүүл анхны дугаартаа манай нам засаг үүссэн өдрөөсөө эхлэн эмэгтэйчүүдийг чөлөөлөх, тэднийг нийгмийн тустай хөдөлмөрт татан оролцуулах, соён гэгээрүүлэх талаар анхаарч зүйл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж ирснийг тусгасан байна. Тус сэтгүүлийн “Бүсгүйчүүдийн тасаг явуулсан ба явуулахаар завдаж буй хэргийн тухай, “Яаран боловсорсугай” зэрэг өгүүлэлд монголын эмэгтэйчүүд ардын хувьсгалын ачаар эрх чөлөөтэй болж нийгэм улс төрийн амьдралд оролцож, соёлжин боловсорч байгааг баримтаар дурдаж, 1924 онд НТХ-нд бүсгүйчүүдийн тасаг байгуулагдсанаас хойш нэг жилийн дотор хийж гүйцэтгэсэн ажлын тухай тодорхой бичжээ. Эмэгтэйчүүдийн тасаг зөвлөлтийн эмэгтэйчүүдийн байгууллагын ажлын туршлагаар эмэгтэйчүүдийг бичиг үсэгт сургах, тухайлбал түр, оюутны, намын зэрэг төрөл бүрийн сургуульд суралцуулах, тэднийг нам, эвлэл, хоршооны гишүүнд элсүүлэх, энгийн эмэгтэйчүүдийн төлөөлөгчдийн болон Мартын 8-ны хурал зэрэгт өргөн оролцуулах, клуб, улаан булан, уран сайхны ажил, анхны оёдлын үйлдвэрт эмэгтэйчүүдийг татан ажиллуулах, нам, улс, олон нийтийн байгууллагын янз бүрийн албан тушаалд тэднийг сонгууль, томилолтоор дэвшүүлсэн зэрэг олон талт ажлын тухай бичжээ.

... Ингэж монголын эмэгтэйчүүдийн хэвлэл манай эмэгтэйчүүдийг феодализм, шарын шашны бурангуй нөлөөнөөс ангижруулж, нийгэм, улс төр, соёлын амьдралд татан оролцуулахаар уриалан дуудсан байна.

... Монголын эмэгтэйчүүдийн сэтгүүлийн 20,3 0-аад оны дугааруудыг сөхөн үзэхэд феодалын нийгэм, улс төр, эдийн засгийн үндсийг устгаж, ард түмэн, түүний дотор хөдөлмөрчин эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалсан засаг захиргаа, эх нялхсын болон сургууль, соёл, пионер, залуучууд, үйлдвэрчний байгууллага үүсч хөгжсөн зорилго, ач холбогдол, тэдгээрийг бэхжүүлэхэд идэвхтэй оролцож байгаа өөрийн орны тэргүүний эмэгтэйчүүд болон зөвлөлтийн эмэгтэйчүүдийн туршлагаас өргөн сурталчилж байв.

“Эмэгтэйчүүдийн санал” сэтгүүлийн 1926 оны нэг дэх дугаарт эх нялхсын эрх ашгийг хамгаалах анхны зөвлөлгөө өгөх газар байгуулж байгаатай холбогдуулан бичсэн “Эхнэр ба нялхсын байдлыг сайнаар хамгаалах тухай” өгүүлэлд түүний зорилго, ач холбогдлыг зөвлөлтийн туршлагаас үндэслэн тайлбарлаад өргөнөөр ирж үйлчлүүлэхийг эмэгтэйчүүдэд уриалжээ.

Мөн тус сэтгүүлийн “Эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хөгжүүлэх зорилго” өгүүлэлд “Энэ насандаа гагцхүү зововч хойд насандаа магад жаргана” гэдэг хуучны харанхуй эзэрхэг балрын сурталд хүлэгдсэний учраас эмэгтэйчүүд ямар ч эрх мэдэлгүй явж ирсэн бөгөөд олон эмэгтэй нөхөд одоогоос нам ба засгийн их хамгаалал тусламжийн завшаанд нэн шамдан эн тэргүүнээ эрдэм бичиг ба улс төрийн зорилго бодлогод сурч боловсрохыг хичээн улмаар эрэгтэй нөхдийн хамт эрх тэгшээр хүчин чармайж чадвал бүрэн эрх чөлөөгөө олж чадна” гэжээ.

...“Ажилчин эмэгтэй” сэтгүүлийн 1929 оны дугаарт бичсэн нэгэн өгүүлэлд хотын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс цэргийн наадам дээр улаан гэрийг байгуулж зураг, лоозон, ном дэвтэр тавьж, идэвхтэн эмэгтэйчүүдийг ухуулагчаар ажиллуулсан ба эмэгтэйчүүдлийн гар урлалын зүйлээр үзэсгэлэн байгуулсны гадна хажууд нь тусгай гэр барьж, түүнд шинэ үеийн айлын байдлыг гэр доторхи бүрэн хэрэглэлийн хамт тавьж үзүүлсэн тухай бичжээ. Үүнээс үзэхэд МАХН-ын программууд, намын удаа дараагийн их, бага, бүгд хурлаас манай орны хөгжлийн тухайн үед дэвшүүлэн тавьж байсан бодлого шийдвэр, эмэгтэйчүүдийн талаар авч байдаг зүйл бүрийн арга хэмжээг өргөн сурталчлах, ялангуяа эмэгтэйчүүдийг эх оронч, интернациональч, хувьсгалч, дайчин, хөдөлмөрч уламжлал, монгол-зөвлөлтийн ард түмний найрамдлын үзэл санаагаар хүмүүжүүлэх, тэднийг эх орныхоо улс төрийн амьдрал, нийгмийн тустай хөдөлмөрт өргөнөөр оролцуулан боловсрол мэргэжил олгох, эх нялхсын эрх ашгийг хамгаалах, ахуй амьдралд нь соёлч боловсон байдлыг нэвтрүүлэх, улс ардын аж ахуй, соёлын тэргүүний сайчуудыг алдаршуулах зэрэг асуудал монголын эмэгтэйчүүдийн хэвлэлийн түүхэн хөгжлийн бүхий л үед түүний хуудсанд гол байрыг эзэлж ирсэн нь тодорхой байна.

Манай орны улс ардын аж ахуйн төрөл бүрийн салбарт ажиллагч олон мянган эмэгтэйчүүдийн дотроос ариун цагаан хөдөлмөрөөрөө шалгарч алдар нэрээ цуурайтуулсан БНМАУ-ын хөдөлмөрийн баатрууд, Ардын Их Хурлын депутатууд, тэргүүн туршлагын эзэд,

шинийг санаачлагчид, социалист хөдөлмөрийн гавшгайчууд болон бүх ард түмний социалист уралдаанд хошуучлагч ажилчин, малчин, сэхээтэн эмэгтэйчүүдийн ажил амьдрал тус сэтгүүлийн хуудсанд гол байр эзэлдэг юм. Жишээ нь, хөдөлмөрийн баатар саальчин А.Авирмэд, ногоочин Д.Долгор, С.Бадамсүрэн, Я.Должинжав, хоньчин Я.Намгаа, тэмээчин Б.Эс, мал туугч Ж.Жагварал, оёдолчин Ц.Амгалан, БНМАУ-ын төрийн шагналт нэхмэлчин Б.Гүнжилам, БНМАУ-ын ардын жүжигчин О.Дашдэлэг, Гавъяат жүжигчин Л.Цогзолмаа, доктор Б.Ичинхорлоо, Р.Цэрэндулам, А.Дулмаа, гавъяат багш Б.Цэвэгжав, гавъяат барилгачин Д.Балжинням нарын зэрэг өдий төдий сайчууд, илгээлтийн эзэн охидын амьдрал хөдөлмөр бүтээлийн тухай хэдэн арван найруулал, сурвалжлага, тэмдэглэл нийтлэгдсэн билээ.

Тус сэтгүүлд МАХН, ардын хувьсгалын анхны зүтгэлтэн партизан, манай эмэгтэйчүүдийн байгууллагын нэрт зүтгэлтэн С.Янжмаа, партизан Г.Цэнд-Аюуш, БНМАУ-ын баатар Т.Бор, Г.Цэнд нарын тухай материал нийтлэгдсэн нь манай залуу үеийг хувьсгалч дайчин, баатарлаг уламжлалаар хүмүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлд "Намын шийдвэр амьдрал", "Эмэгтэйчүүдийн тэргүүний зөвлөл", ахмадын, хүүхдийн, эмчийн болон ашигтай зөвлөлгөө зэрэг байнгын булан гарч байна. Мөн ахуйн соёлын зарим асуудлаар бага хурал явуулж ирлээ.

... Ах дүү социалист орны эмэгтэйчүүдийн ажил амьдрал, социалист байгуулалтын ололт амжилтууд болон ДАЭХ-ны үйл ажиллагааны тухай манай сэтгүүл байнга нийтэлж байна. 1925 онд тус сэтгүүл 2000 хувь хэвлэгдэж байсан бол одоо 55000 хувь хэвлэгдэн гарах болж ажилчин, малчин, сэхээтэн олон зуун бичигч идэвхтэнтэй болов. Бид бичигч идэвхтнээсээ жил тутам олон зуун захидал, мэдээ хүлээн авч олонхийг сэтгүүлдээ нийтэлж байдаг юм.

Манай бичигч идэвхтний дотроос Хэнтий аймгийн "Урагшаа" сонины ажилтан Б.Халтар, Завханы "Туяа" сонины Ш.Содномцэрэн, Архангайн Жаргалант сумын сургуулийн багш Д.Гүррагчаа, Өвөрхангайн нийтийн аж ахуйн үйлчилгээний газрын ажилчин Д.Дуламсүрэн, Говь-Алтайн кино механикч Ж.Гомбо, Увс аймгийн Малчин сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Ц.Дэмбэрэл нарын зэрэг тэргүүний бичигчдийг тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

... Аймаг, хотын эмэгтэйчүүдийн зөвлөлүүд сэтгүүл сурталчлах гэгээрлийн хурал хийлгэх, нийтлэгдсэн материалаар асуулт хариултын маргаан, уулзалт үдэшлэг, өдөрлөг, радио нэвтрүүлэг зохиох, аман дугаар гаргах, сэтгүүлийн нэрэмжит өндөр бүтээлийн өдөр, 7,10 хоног, сарын ажил зохиож сэтгүүлийн захиалга, тараалт, ашиглалтын байдлыг сум, албан газарт шалгаж заавар зөвлөлгөө өгсөн нь нэлээд үр дүнтэй болов.

Нөхөд өө!

"Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарснаас хойш өнгөрсөн 50 жилд монголын эмэгтэйчүүдийн шинэ шинэ үеийг хүмүүжүүлэх, оюун санааны хэрэгцээг хангах, ололт амжилтыг нь сурталчлах жинхэнэ индэр болж ирлээ. Манай баярын хуралд МАХН-ын Төв Хорооноос ирүүлсэн баярын бичигтээ "Монголын эмэгтэйчүүд сэтгүүлийн цаашдын зорилтыг яруу тод зааж өглөө.

Эрхэм нөхөд өө!

Олон улсын эмэгтэйчүүдийн жилд хөдөлмөр сурлагын өндөр амжилт олж, эх орныхоо улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 5 дугаар таван жилийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, давуулан биелүүлэхийг Та бүхнээс хүсч, эрүүл энх аз жаргал, сайн сайхны ерөөл дэвшүүлье гэжээ.

Монголын эмэгтэйчүүдийн сэтгүүл үүсч хөгжсөны 50 жилийн ойг тохиолдуулан 1975 онд, 60 жилийн ойг тохиолдуулан 1984 онд "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүлийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор хоёр удаа шагнажээ. Эдгээр одонгууд одоо МЭХ-нд хадгалагдаж байна. Эмэгтэйчүүдийн сэтгүүлийг сэргээн эмэгтэйчүүдийн унших дуртай хэвлэлийн нэг болгон хөгжүүлэхэд сэтгүүлийн эрхлэгч Т.Должин, Э.Оюун, Б.Хэнмэдэх, Ж.Алтанцэцэг, хариуцлагатай нарийн бичгийн дарга Ч.Батчулуун, сэтгүүлч И.Эрдэнэчимэг, Н.Дамбий нарын уйгагүй хөдөмөр, идэвх зүтгэл чухал үүрэг гүйцэтгэсэн юм. "Монголын эмэгтэйчүүд" сэтгүүл олон идэвхитэн бичигчтэй байсны нэг нь монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн зохиолч, яруу найрагч Ш.Дулмаа болой.